



ЦАХИМ ШУУДАНД

**ИХ ГОВИЙН ГАРИНЗОНД ШААРДЛАГАТАЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ ГАРДУУЛАВ**



Дорноговь аймгийн ИТХ-ын төлөөлөгч Л.Наранбаатар, Ц.Болормаа нар коронавирусууд урьдчилан сэргийлэх ариутгалын мананцар үүсгэгч, автомат халуун хэмжигчийг Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн хамт олонд хүлээлгэн өгсөн юм. Ангийн захирагч, хурандаа А.Болдбаатар тэдэнд бидний ажлыг дэмжин ажиллаж байгаад талархаж цаашид хамтран ажиллахаа илэрхийллээ.

**ХАНБАЯНЗҮРХ ХАЙРХАНД СЭРГЭЭН БОСГОЛТОД ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 336 ДУГААР АНГИЙН ХУВЬ НЭМЭР ДУНДАРШГҮЙ ...**

Ханбаянзүрх хайрханы овоонд үер, уснаас үүссэн эвдрэл гэмтлийг сэргээн засах, сайжруулах ажилд Зэвсэгт хүчний 336 дугаар ангиас хошууч Д.Булганням ахлагчтай 20 офицер, ахлагч нар хоёр өдрийн хугацаанд туслалцаа үзүүлж сэргээн засварлаж дууслаа.



Дэслэгч Ч.БОДЬГЭРЭЛ

**УЛААНБААТАР ХОТОД ЯВУУЛЫН НЭГ, СУУРИН 59 ЦЭГТ ИРГЭДИЙГ ДАРХЛААЖУУЛНА**

Улаанбаатар хотод өнөөдөр суурин 52 цэгт 61 багийн 442 эмч, ажилтан ажиллаж, 4392 иргэнийг коронавирусний

эсрэг дархлаажуулахаар төлөвлөжээ. Мөн шинжилгээний зургаан цэг 09:00-12:00 цагийн хооронд

ажиллана. Шинжилгээний болон дархлаажуулалтын цэгүүдийг дүүрэг тус бүрээр танилцуулж байна.

**ИРГЭДИЙН ТӨГРӨГИЙН ХАДГАЛАМЖ ЖИЛИЙН ХУГАЦААНД 3.9 ИХ НАЯДААР НЭМЭГДЭВ**



Долоодугаар сарын эцсийн урьдчилсан гүйцэтгэлээр мөнгөний нийлүүлэлт (M2) 27 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5.6 (25.9 %) их наяд төгрөгөөр өсжээ. Үүнд 1. валютын харилцах 83.2 (3.8%) тэрбум төгрөгөөр

2.төгрөгийн харилцах 1.9 (67.3%) их наяд төгрөгөөр 3.төгрөгийн хадгаламж 3.9 (34.7%) их наяд төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ. Иргэдийн төгрөгийн хадгаламж өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.9 их наядаар нэмэгдсэнийг

ҮСХ-ны дарга Б.Батдаваа танилцуулав.

2020 оны эхний долоон сарын байдлаар иргэдийн төгрөгийн хадгаламж 11.2 их наяд төгрөгтэй тэнцүү байсан бол энэ оны мөн үед 15.1 их наяд төгрөгтэй тэнцүү байна.

Төгрөгийн хадгаламж өмнөх сараас 156.8 тэрбум төгрөг буюу 1 хувь, өмнөх оны мөн үеэс 3.9 их наяд буюу 34.7 хувиар өсжээ. Төгрөгийн хадгаламжийн

4. 89.3 хувь (13.5 их наяд төгрөг) нь иргэдийн хадгаламж

5. 10.7 хувь (1.6 их наяд төгрөг) нь аж ахуйн нэгж, байгууллагын хадгаламж байна. Валютын хадгаламж 4.1 их наяд төгрөг болж, өмнөх сараас 200.7 (4.7%) тэрбум төгрөгөөр, өмнөх оны мөн үеэс 496.0 (10.8%) тэрбум төгрөгөөр буурчээ.

ДЭЛХИЙД

**ШИНЭ ЗЕЛАНДАД ХӨЛ ХОРИО ТОГТООЖЭЭ**



Шинэ Зеландын Ерөнхий сайд Жасинда Ардерн "COVID-19"-өөр дотоодод халдварласан тохиолдол энэ оны хоёрдугаар сараас хойш анх удаа бүртгэгдсэнтэй холбогдуулан орон даяар хөл хорио тогтоож буйг мэдэгджээ.

хэвлэлийн бага хурлын үеэр Ж.Ардерний мэдээлснээр, эрүүлмэндийн байгууллагын мэргэжилтнүүд уг тохиолдлын генийн дарааллыг тогтоох шинжилгээг хийж байгаа ч хурдан халдварладаг "Дельта" хувилбараар халдварласан гэж таамаглаж байна.

Мягмар гарагт болсон

Тодруулбал, Шинэ Зеландын хамгийн том хот болох Оклендын оршин суугч, 58 настай эрэгтэйн шинжилгээний хариу эерэг гарчээ. Вакцинд хамрагдаагүй байсан эрэгтэй улсын бусад хэсэгт зорчсон бөгөөд хилийн чанадтай холбоотой гэх тодорхой мэдээлэл байхгүй байна.

"Улсын хэмжээнд орон нутгийн цагаар мягмар гаргийн шөнө дундаас эхлэн гурван хоногийн турш хатуу хөл хорио тогтооно" гэж Ж.Ардерн мэдэгджээ. Ийнхүү дөрөвдүгээр түвшний хөл хорио тогтоосноор бүх иргэн гэртээ байх ёстой бөгөөд супермаркет, эмийн сан гэх мэт нэн шаардлагатай үйлчилгээнээс бусад бизнесийн үйл ажиллагааг зогсооно.

**АФГАНИСТАНЫ ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ ӨӨРИЙГӨӨ ТҮР ЕРӨНХИЙЛӨГЧӨӨР ЗАРЛАЖЭЭ**

Афганистаны дэд ерөнхийлөгч Амрулла Салех өөрийгөө тус улсын түр Ерөнхийлөгчөөр зарлалаа.

"Хэрэв Ерөнхийлөгч эх орноосоо зугтан гарсан, огцорсон эсвэл таалал төгссөн тохиолдолд дэд ерөнхийлөгч нь түр Ерөнхийлөгч болно гэж Афганистаны Үндсэн хуульд заасан байдаг. Би одоогоор эх орондоо байгаа бөгөөд хууль ёсны түр Ерөнхийлөгч юм. Бүх удирдагчтай зөвшилцөж, дэмжлэгийг нь авахын тулд тэдэнтэй холбоо тогтоож байна" гэж Амрулла Салех твиттер хуудсандаа бичжээ.

Тэрбээр иргэддээ хандан, талибуудын эсрэг зогсохыг уриалсан байна. "АНУ, НАТО-гоос ялгаатай нь бид мөн чанараа алдаагүй бөгөөд ирээдүйд асар их боломжуудыг харж байна. Хий хоосон анхааруулга дууслаа. Эсэргүүцэлд нэгдээрэй" гэж



Амрулла Салех онцлон тэмдэглэжээ.

Хэдэн долоо хоногийн өмнө Афганистанаас АНУ-ын цэргүүд гарахтай зэрэгцэн тус улсын байдал эрс дордож, талибууд томоохон хотууд руу дайрч эхэлсэн юм. Ням гарагт тэд Кабулыг бүрэн хяналтдаа авч, эрх мэдлийг булаан

авсан бол тус улсын Ерөнхийлөгч асан Ашраф Гани эх орноосоо зугтан гарсан билээ.


Афганистанд 20 жил үргэлжилсэн дайн дуусаж, засаглалын шинэ хэлбэр удахгүй тодорхой болно гэж "Талибан" хөдөлгөөний улс төрийн газрын албан ёсны төлөөлөгч Мохаммад Наим мэдэгджээ.




**КОРОНАВИРУСТ ХАЛДВАРЫН ЭСРЭГ ДАРХЛААЖУУЛАЛТЫН 8 ДУГААР САРЫН 18-НЫ ӨДРИЙН ТӨЛӨВЛӨЛТ**

№	ДУҮРГИЙН НЭР	БАГИЙН ТОО	АЖИЛЛАХ ХҮНИЙ ТОО	ХАМРАГДАХ ХҮНИЙ ТОО
1	БАГАНУУР	1	8	50
2	БАГАХАНГАЙ	1	5	36
3	БАЯНГОЛ	10	48	910
4	БАЯНЗҮРХ	8	77	680
5	СОНГИНОХАЙРХАН	23	199	830
6	СҮХБААТАР	5	36	856
7	НАЛАЙХ	1	12	42
8	ЧИНГЭЛТЭЙ	6	23	770
9	ХАН-УУЛ	9	56	830
10	ЯВУУЛЫН БАГ	1	6	80
	<b>НИЙТ</b>	<b>68</b>	<b>494</b>	<b>5084</b>

1 ЯВУУЛЫН, 59 СУУРИН ЦЭГТ 68 БАГИЙН 494 ЭМЧ, АЖИЛТАН АЖИЛАЖ 5084 ИРГЭНИЙГ ДАРХЛААЖУУЛНА



ЦАХИМ ХАЯГ



ЦАХИМ ХУУДАС



\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.  
\* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.  
\* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018

Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn Утас: 70001029, 3412 (дотуур)